



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 471

Дархан

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, 33.1.11. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /COVID-19/-тай тэмцэхэд халдварын тандалт, сэргийлэлт, оношлогоо, эмчилгээ, дархлаажуулалт, ар талын хангалтын арга хэмжээнд дайчлагдаж буй эмнэлгийн ажилчдын эрүүл мэнд, халдварын хамгаалал, ахуйн зарим шаардлагатай хангамжийн бэлэн байдлыг хангах болон ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд дархлаажуулалт, халуун хоол, халдвар хамгааллын хэрэгсэл, шаардлагатай бусад хангамжийн хэрэгцээг тодорхойлж хангах үйл ажиллагааг сар бүр зохион байгуулж ажиллахыг Эмийн мэргэжилтэн /А.Дэлгэрмаа/, Эм, эмнэлгийн хэрэгсэл хариуцсан бага эмч /Ц.Оюунтуяа/, нярав /В.Цэрэнжав/, Эм, эмнэлгийн хэрэгслийн тендер хариуцсан бага эмч /Ц.Алтанцэцэг/ нарт үүрэг болгосугай.

2. Дархлаажуулалт, халуун хоол, шаардлагатай бусад хангамжийн хэрэгцээнд шаардлагатай хөрөнгийг сар бүр зориулалтын ангиллаас зардлыг гаргахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга /Б.Эрдэнэчимэг/-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох бараа материалын зүйлийг нягтлан бодох бүртгэлийн дагуу бүртгэж, сар бүр тайлагнахыг Тооцооны нягтлан бодогч /Х.Уранчимэг/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн /Ч.Мөнхцэцэг/, Эдийн засаг, төсвийн төлөвлөлт, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Б.Болднасан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БАТЦЭНГЭЛ

